



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

“Шарын гол” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 25, 42 дугаар зүйл, Үнэт цаасны бүртгэлийн журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шарын гол” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,231,389 /арван сая хоёр зуун гучин нэгэн мянга гурван зуун наян ес/ ширхэг энгийн хувьцаанаас арилжигдаагүй үлдсэн 61,147 /жаран нэгэн мянга нэг зуун дөчин долоо/ ширхэг энгийн хувьцааг хасаж нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,170,242 /арван сая нэг зуун далан мянга хоёр зуун дөчин хоёр мянга/ ширхэг энгийн хувьцаа байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

2. Холбогдох мэдээ тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж, нийтэд мэдээлэх, хууль тогтоомж болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Шарын гол” ХК /Б.Батмөнх/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

000924